

## **ХБӨ/ЗСӨ-НИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН НЭН ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦЫГ НЭВТРҮҮЛЭХ “МОНПЭН” ТӨСӨЛ**

1. **Төсөл арга хэмжээний нэр:** ХБӨ/ЗСӨ-ний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлэх “МонПЭН” төсөл
2. **Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага:** Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)
3. **Төсөл арга хэмжээний зорилго:** Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд ДЭМБ-ын ХБӨ/Зүрх судасны өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (PEN)-ыг нэвтрүүлж, хүн амд зөвлөгөө өгөх арга хэмжээг өргөжүүлэх
4. **Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд.
5. **Төсөл арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр (гадаад, дотоод)** Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
6. **Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт (тооцоо нийлсэн дүнгээр)** 68,602,040 төгрөг
7. **Төсөл арга хэмжээний нийт ашиглалт (өссөн дүнгээр)** 72,320,116 төгрөг
8. **Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:** ,
9. **Тайлант хугацаанд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлууд:**
  - а. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, 13 сум, 2 өрхийн Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн эмч, мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж явуулсан.
  - б. 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 бүлэг 19 заалт арга хэмжээг тусган аймгийн Засаг даргаар батлуулж гаргасан. Аймгийн Засаг даргатай сумдын Засаг дарга нарын 2022 онд хэрэгжүүлэх ажлын үр дүнгийн гэрээнд “МонПЭН” санаачлагыг сум орон нутгийн түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх” заалтыг тусган оруулсан.
  - в. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 2022 оны 3 дугаар сард “МонПЭН” санаачлага төслийн үйл ажиллагаанд “Дэмжлэгт хяналт”-ыг Гурвансайхан, Эрдэнэдалай, Луус, Сайнцагаан, Дэрэн сумдад зохион байгуулж, сумын Засаг дарга, Засаг даргын тамгийн газрын дарга нарт танилцуулга мэдээллийг хийсэн.
  - г. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр 2022 оны 11 дүгээр сард “МонПЭН” санаачлага төслийн үйл ажиллагаанд “Дэмжлэгт хяналт”-ыг Говь-Угтаал, Сайхан-Овоо, Адаацаг, Сайнцагаан сумд, Боржигон Мандал, Өлзийт Мандал өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулж, сумын

Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт танилцуулга мэдээлэл, ухуулга нөлөөллийн хийсэн.

**10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд:**

а. Цаашид 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг улирал бүрээр гарган хэрэгжүүлж тухай бүр үр дүнг тооцон ажиллахаар төлөвлөж байна.

б. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдлэг олгох, бататгах, чадавхжуулах сургалтыг зохион байгуулж явуулах.

в. Хүн амын хамрагдалт, хяналт, эрүүлжүүлэлтийг нэмэгдүүлэх.

**11. Тулгамдаж буй асуудлууд:**

а. Хүний нөөцийн дутагдалтай байдал.

б. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал.

в. Үзлэгийн программын хөгжүүлэлтийн асуудлууд.

**12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

МонПЭН санаачлагыг 2023 онд улирал бүрийн төлөвлөлтөөр зохион байгуулж оны эцэст хүн амын 80 дээш хувийг хамруулсан байхаар төлөвлөж байна.

**13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:**

а. Төслийн захирлын нэр: Б.Алтантөгс

б. Төслийн зрхицуулагчийн нэр: Ц.Загдсүрэн

в. Хаяг: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, С.Буяннэмэхийн өргөн чөлөө 1-103

г. Холбоо барих утас: (976) 70593894

д. Цахим шуудангийн хаяг: [em\\_gazar@dundgovi.gov.mn](mailto:em_gazar@dundgovi.gov.mn)